



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/311

Номгон

「 Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг
судлах, санал дүгнэлт гаргах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.10, Усны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шаргалжуут рашаан сувилал нь жилийн 4 улиралд ажилладаг болсон тул ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг судлах, санал дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

- | | |
|----------------------|--|
| Т.Хишигбаатар | (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга) |
| Гишүүд: Д.Сарангарав | (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга) |
| Ш.Даваабат | (Санхүү, төрийн сангийн хэлтсийн Орлогын мэргэжилтэн) |
| Б.Өсөхбаяр | (Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн дарга) |
| Б.Ням-Очир | (Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дарга) |
| Б.Зүгдоржав | (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал, төрийн бус байгууллага, судалгаа, шинжилгээ хариуцсан мэргэжилтэн) |
| Л.Энхтогтох | (Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны Усны чанар, экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн) |
| Ц.Доржнамжин | (Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны Газрын доорх усны нөөц, хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн) |
| М.Мөнхбат | (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн) |

642310781

Нарийн бичгийн дарга:

Б.Намуун


(Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн)

2.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Хишигбаатар)-д үүрэг болгосугай.

3.Дээрх төлбөрийг судалж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар оруулж хэлэлцүүлэхийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар), Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН